

1

Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн он.....сар.....өдөр.....цаг.....
Дууссан он.....сар.....өдөр.....цаг.....**СЭДЭВ: МОНГОЛ ЕРӨӨЛ МАГТААЛ****АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР:**

Магтаал нь аливаа зүйлийн сайн сайхан шинжийг тоочин дүрсэлж, бахархан сайшаах утгыг илэрхийлсэн байдаг. Магтаалыг тодорхой айзам хэмжээ бүхий тусгай хөг аялгуугаар хэлэх ба одоогийн байгаа сайн сайхныг нь магтан батжуулахын зэрэгцээ орчин тойрныхоо юмс үзэгдлийг сүслэн дээдэлж, уран яруу үгээр магтан мялааж шүлэглэсэн байдаг онцлогтой.

Ерөөл нь ерөөгч тухайн үеийн байдлыг магтахаас гадна ирээдүйн сайн сайхныг бэлгэшээн хүсэж, аялгуулан хэлдэг аман зохиолын төрөл юм. Ерөөлийн гол онцлог нь нэгдүгээрт, ерөөгчийн зөн билиг, бэлгэдэлт сэтгэлгээ, ирээдүйн тухай хүслэнг шингээсэн байдаг, хоёрдугаарт, дүрсэлж байгаа зүйлээ урнаар, бэлгэ дэмбэрэлт санаагаар баяжуулан тоочин хэлдэг байна.

Дасгал 1. Монгол ерөөл магтаалыг уншиж, ойлгоё.

Алхам 1. 7 дугаар ангийн сурах бичгийн 9 дүгээр талаас “Хангайн магтаал” -ыг уншъя. Магтаалын ямар үг хэллэг сонирхлыг чинь хамгийн их татсан бэ?

.....

.....

.....

Алхам 2. Үгийн утгыг мэдье. Учир нь үгийн утгыг мэдэхгүй бол бид ямар ч эхийг бүрэн ойлгож чадахгүйг ямагт санаарай.

“Хангайн магтаал”-ын дараах үгсийг тольдон тайлбарлая.

Үг	Үгийн тайлбар	Үг	Үгийн тайлбар
Өлөн өвс	Ширэг, чийгтэй газар ургасан нэгэн төрөл өвс	Мэхээрийн бор	Мэхээр хурааж нөөцлөн иддэг жижиг хулгана
Борог өвс	Хөхөрч шарлаж унасан хагд өвс	Рашаан тамир ханхалсан	Рашааны эдгээх хүч цогцолсон
Өрөөлдөж тавьсан морь	Морины урд хойд хоёр хөлийг холбон туших	Гундаа шар нуруу	Намар уулын мод шарлаж, гандаж гундсан мэт харагдах
Харцагаа түрэн урамдах	Намар буга урамдах үед сээр ууц хоёрын дундах харцага яс хөдлөхийг хэлж байна.	Өлзийтэйхэн хангай	Тойрон амьдрах ард олонд ээл ивээлээ хайрлах гэсэн утга
Гунан хар бүргэд	Ид насанд хүрч, хүч чадал нь багтаж ядсан бүргэд	Суу халиу	Усны халиу

1. Магтаалд “Хангай хан”-ыг ямар улиралд магтаж байна вэ?

.....

Ямар ямар шинжээр нь тэгж бодож байна вэ? Жишээ бичье.

.....

Яагаад заавал энэ улирлыг сонгон магтсан юм бол? Өөрийн бодлоо бичье.

.....

.....

Алхам 3

Асуултад дараалын дагуу хариулж, “Хангайн магтаал”-ын талаар эргэцүүлье.



“Хангайн уул бол маш олон хүн, амьтны амьдралд ач тустай, үзэмж төгөлдөр сайхан нутаг учир хүн бүр хайрлан хамгаалж, дээдлэн үзэх хэрэгтэй юм” гэж магтаалын гол санааг дүгнэж болох уу? Чи юу гэж бодож байна вэ?

2. Асуултад хариулъя. Өөрөө мэдэхгүй бол ахмад хүнээс лавлаарай.

- 1. “3 тохой хурц тоорой мод нь дөрөө зурам...” гэсэн хэсгийн “Тоорой” мод хаана ургадаг вэ?
- 2. ...”Идэр Тэрхийн өвгөн буурал, баян хангай”гэсэн хэсэгт дурдагдаж байгаа голууд хаана байдаг вэ?

.....

.....

Хариултаас үүдэн хариулъя.

Хангайн нуруу монголын говь, хангай нутгийг дамнан оршдог гэдгийг магтаалын дээрх жишээгээр баталж болох уу?

.....

.....

3. “Хангайн магтаал”-аас дараах утгын зүйлчлэлд жишээ бичье.

1. Гол усны нэр

2. Ургамлын нэр

3. Амьтны нэр, зүс

.....

Эдгээрийг магтаалд тоочсоны учрыг чи юу гэж бодож байна вэ?

.....

.....

.....

Дараах холбоосоор, “Алтайн магтаал”-ыг сонсоорой.
<https://www.youtube.com/watch?v=EsaZHngmblo>

Монгол хүний амьдрал ахуйд байгаль, эх нутаг нь маш чухал ач холбогдолтойн учир хийгээд монголчуудын газар нутгаа хайрлан хүндлэх ёс, зан заншлын талаар чи юу мэдэх вэ? Товч бичье.

.....

.....

.....

.....

.....

.....

2

Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн он.....сар.....өдөр.....цаг.....
Дууссан он.....сар.....өдөр.....цаг.....

СЭДЭВ: МОНГОЛ ЕРӨӨЛ МАГТААЛ

АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР:

Зохиолчийн үг сонголтын шалтгааныг тайлбарлана гэдэг нь, зохиолч үзэл бодлоо илэрхийлэхдээ, мөн зохиолын дүрээ урлахдаа ямар үгийг, яагаад сонгон хэрэглэснийг ажиглан, жишээ баримтаар тайлбарлан судална гэсэн үг юм.

Уран дүрслэл: Өгүүлж хэлэх санааг уран сайхан, уянга яруу, содон сонирхолтой илэрхийлэх арга хэрэглүүрийн хэлнэ. Үүнд:

Адилтгал: Уран дүр гаргах хамгийн гол арга юм. Хоёр юм үзэгдлийн адил төстэй шинжээр нь жишиж, харьцуулан шинэ шинжийг дүрслэх хэрэглүүр юм.

Амьдчилал: Амьд юмны шинж чанарыг төстэй байдлаар нь амьгүй бодист шилжүүлэн дүрслэхийг хэлнэ. Жишээ нь: “Зүү чамайг дагаж, зүггүй их явлаа. Одоо больё, ондоо замаар явъя. Өөрчлөлт хувьслын үед өөр замаар явъя” гэж утас нэг удаа ууртай хэллээ.
(Д.Батжаргал “Утас зүү хоёр” шүлэг)

Хэтрүүлэл: Юмсын шинж чанарыг хэт ихэсгэн эсвэл хэт багасган дүрслэх арга.

- ✓ **Ихэсгэл:** Юмс үзэгдэл, үйл явдлын аль нэг шинж төрхийг уран сайхнаар ихэсгэн давуулж дүрслэхийг /ихэсгэл/ гэнэ. Жишээ нь:
- ✓ “...Далан хүн даадаггүй далай цагаан шаазангаар айраг нэг дүүргэж...”
(Эрийн сайн Хан Харангуй тууль)
- ✓ **Багасгал:** Багасгал нь ихэсгэлийн эсрэгээр юм үзэгдэл, үйл явдлын шинж байдлыг багасган хэтрүүлэх уран сайхны дүрслэлийн арга юм.

Дасгал 1. Зохиолын үг сонголт, уран дүрслэлийн үүрэг, хэрэглээг шинжилье.

Алхам 1. 7 дугаар ангийн сурах бичгийн 12-13 дугаар талаас “Таван хошуу малын магтаал” -ыг уншъя. “Таван хошуу мал”-ын магтаалыг уншихад “Хангайн магтаал”- аас ялгаатай ямар бодол, сэтгэгдэл төрсөн бэ?

.....

.....

.....

Алхам 2. Магтаалд таван хошуу малын шинж байдлыг дүрсэлсэн үгсийг хүснэгтэд нөхөж бичээд, мэдэхгүй үгийн утгыг толь бичгээс болон ахмад хүнээс мэдэж аваарай.

	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа
Зан авир					
Явдал					
Нас шүд					

Алхам 3

Адууг ямар уран дүрслэл хэрэглэж магтсан байна вэ? Дугаарын ард тохирох үсгийг бичье.

Адуу

1. Хулан хоёр чихтэй
2. Хатирч хүрэхгүй бэлтэй
3. Харваж хүрэхгүй зэлтэй

- А. Ихэсгэл
- Б. Адилтгал
- В. Ихэсгэл

Дараах уран дүрслэл хэрхэн бүтсэн байна вэ?

Тэмээ

1. Хонин шар нүдтэй - Адилтгал
2. Ширээ бөхтэй - Адилтгал
3. Ширэм тавагтай - Адилтгал
4. 30 хуруу зогдортой - Ихэсгэл

Жишээ нь: “Хонин шар нүдтэй”- Хонь, тэмээ хоёрын нүдний өнгөний төстэй байдлаар нь адилтгасан.

.....

.....

.....



Уран дүрслэлээр зохиолчийн ямар үнэлэмж, хандлага илэрч байна вэ?

Үхэр

Эргээд барагддаггүй
 Ивэлгээд хүчрэгддэггүй...
 Хангай бугын гүйдэлтэй...
 Жад ороонгон эвэртэй
 Жартгай дайсанд амтай...

Жишээ нь: “Эргээд барагддаггүй” –тойрч барагдашгүй олон гэсэн санаа бөгөөд энэ нь мал сүргээ тоо томшгүй олон болог гэсэн зохиолчийн хандлага илэрсэн.

.....

Уран дүрслэлийг зургаар үзүүлье.

Ямаа

Сэлмэн дэрлэгэр эвэртэй
 Цэцэг цоохор зүстэй
 Ямагт хошуучлах ааштай



Уран дүрслэл нь малын шинжийг дүрслэхэд ямар үүрэгтэй байна вэ?

Хонь

- Халив сүүлтэй
- Хунгийн дуутай
- Дунгийн зүстэй

Жишээ нь: “Халив сүүлтэй”

Хонины тарга хүчийг үзүүлэхийн тулд тогооны тагийн дугуй хэлбэртэй адилтгасан.

.....

.....

.....

Магтаалд тооны нэрээр бүтээсэн ахиулал нь ямар бэлгэдэл илэрхийлж байна гэж бодож байна вэ?

Адуу мянга, тэмээ түм, үхэр бум, хонь сая, ямаа живаа

.....

3

Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн он.....сар.....өдөр.....цаг.....
Дууссан он.....сар.....өдөр.....цаг.....

СЭДЭВ: МОНГОЛ ЕРӨӨЛ МАГТААЛ

АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР:
 Шүлгийн нэг мөрийг шүлгийн шад гэнэ.
 Толгой холбох: Шүлгийн шадын эхний авиаг ижилсүүлэхийг толгой холбох гэнэ.
 Сүүл холбох: Шадын төгсгөлийг адилсуулан холбож хэмжээ тэнцүүлснийг сүүл холбох гэнэ.
 Монгол шүлэгт толгой холбоц чухал үүрэгтэй. Толгой холбох хэлбэрүүд нь:

A	A		A		A	
A	A	Зэрэгцэх	B	Салаавчлах холбоц	B	Хаших
A	B	холбоц	A		B	холбоц
A	B		B		A	

Шүлгийг толгой, сүүл холбосноор шүлгийн айзам хэмнэл бүрдэж, уран яруу, сонсголонтой болдог.

Дасгал 1. Шүлэглэсэн зохиолын шад, холбоцыг тайлбарлая.

Алхам 1. “Таван хошуу малын магтаал”-ын хэсгийг уншиж, шүлгийн мөрүүдийг хэрхэн зохион байгуулсныг ажиглая. Жишээнээс үзэхэд, шүлгийн шадуудын эхний авиаг хос хосоор нь зэрэгцүүлэн толгой холбосноос гадна мөн сүүлийг хосоор нь адил төгсгөлөөр холбож, дүгнэлт шадын сүүлийг сондгойруулах арга хэрэглэсэн байна. Мөн хосолсон шад бүр адил тооны үг, ойролцоо тооны үеэс / 4-5,6-7/ бүрдсэнийг анхаараарай.

Хангай царамд нутагтай Хандгай бугын гүйдэлтэй Сүүл саваг сайтай Сүү шим ихтэй Жад оронгон эвэртэй Жартгай дайсанд амтай Хар тарлан алаг Хайнаг сарлагийн чинь Буян хишиг дэлгэртүгэй	Хан-гай ца-рамд ну-таг-тай / 3 үг, 7 үе/ Ханд-гай бу-гын гүй-дэл-тэй /3 үг, 7 үе/ Сүүл са-ваг сай-тай /3 үг, 5 үе/ Сүү шим их-тэй /3 үг 4 үе/ Жад о-рон-гон э-вэр-тэй /3 үг, 7 үе/ Жарт-гай дай-санд ам-тай /3 үг, 6 үе/ Хар тар-лан алаг /3үг, 5 үе/ Хай-наг сар-лаг-ийн чинь / 3 үг, 6 үе/ Буян хи-шиг дэл-гэр-тү-гэй / 3 үг, 7 үе/
---	---

Алхам 2. Магтаалын хэсгийн бүтцийг тодорхойлъё..

Эмээлийн магтаал	Тодорхойлолт
Малын арьсан захтай	
Магнаг торгон тохомтой	
Толь дүгрэг хазаартай
Торгон утсан оломтой
Хүрэл болд дөрөөтэй
Хөмөлдрөг хударга чимэглэлтэй	

Дүгнэлт: “Эмээлийн магтаал” -ын хэсгийн шадын толгой холбоц нь: _____, сүүл холбоц нь _____, шад тус бүрийн үгийн тоо нь _____ үе нь _____ байна. Иймээс айзам хэмнэлтэй, уран яруу аялгуулан уншихад дөхөм болж байна.

4

Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн он.....сар.....өдөр.....цаг.....
Дууссан он.....сар.....өдөр.....цаг.....**СЭДЭВ:** МОНГОЛ ЕРӨӨЛ МАГТААЛ

Дасгал 1: Шүлэг зохиоё.

	<p>A- урд бүүрэг B- хяр C- даруулга D- олонцог E- хойд бүүрэг F- баавар G- хойд ганзага H- дэвс I- тохом J-дөрөө K-дөрөөний сур L-дугтуй M- гөлөм N-урд ганзага O- хавтас</p>	<p>Алхам 1. 7 дугаар ангийн сурах бичгийн 15 дугаар талаас “Эмээлийн магтаал”-ыг уншиж, шүлэглэсэн аргыг ажиглая.</p> <ul style="list-style-type: none"> Эмээлийг магтахдаа түүний бүрдэл хэсгүүд болон гадаад шинж, хэрэглээний онцлог, бүтсэн эд зэрэг юу, юуг нь магтсаныг сайтар анхааръя.
---	---	--

Алхам 2: Юмсын гадаад шинжийг дүрслэн магъя.

Бичихийн тулд анхааръя.

Магтах зүйлээ сонгоё. Гудамж талбай, унаа морь, машин техник, сургууль ...

- Уг зүйлийнхээ гадаад төрх байдлыг бүртгэж бичье.
- Магтах зүйлийнхээ бүтцийг ажиглаж, тэмдэглэж авъя.
- Бичсэн гадаад төрхийг тэмдэглэсэн үгсийг тэмдэг нэр, адилтгал, амьдчилал, хэтрүүлэл зэрэг уран дүрслэлийн аргаар дэлгэрүүлье.
- Юунаас, хаанаас нь эхэлж магтахдаа тогтооё.
- Толгой сүүл холбож, шадын үг, үеийн тоог тэнцүүлье
- Бахархсан, магтсан өнгө аясаар бичье.
- Бичсэн зүйлсээ нэгтгэн магтаалаа бичье.
- Бичсэн магтаалдаа ирээдүйн сайн сайхныг ерөөсөн агуулгатай 2 шад нэмье
- Бичсэн магтаалаа засан сайжруулъя

5

Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн он.....сар.....өдөр.....цаг.....
Дууссан он.....сар.....өдөр.....цаг.....**СЭДЭВ: ТҮҮХЭН ДОМОГ****АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР:**

Түүхэн домог гэдэг нь хэзээ нэг цагт болж өнгөрсөн үйл явдлыг уран сэтгэмжээр ургуулан баяжуулсан аман зохиол юм. Домгийн үйл явдал бүхлээрээ үнэн байх албагүй бөгөөд түүхэн хүн, түүхэн үйл явдлын ямар нэг үнэн улбаа байхад л хангалттай. Энэ улбааг домгийн түүхэн үндэс гэдэг. Түүхэн домог нь зохиогдсон үеийнхээ ахуй соёл, түүх, сэтгэлгээний онцлогийг хадгалан үлддэг байна.

Түүхэн домгийг дотор нь угсаатны түүхэн домог, түүхт хүний домог, аж байдлын домог гэх зэргээр ялгаж болно.

Дасгал 1. Монгол түүхэн домгийг уншиж, ойлгоё.

Алхам 1. 7 дугаар ангийн сурах бичгийн 31-3- дугаар талаас “Мэргэн Жа Гүний түүхэн домог” зохиолыг уншъя.

Алхам 2. Түүхэн домгийг ойлгохын тулд тухайн үеийн соёл, түүхийн талаар тодорхой мэдлэгтэй байх ёстой тул мэдээллийг анхааралтай уншиж ойлгоё..

Түүхэн холбогдолтой үгс	Тайлбар
Жонон засгийн хошуу	Одоогийн Баянхонгор аймгийн Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг сумд
Тэргүүн зэрэг тайж	Чингис хаан болон түүний дүү нарын үр хойчсыг тэмдэглэсэн цол. Тайж нь дотроо тэргүүн, дэд, гутгаар, дөтгөөр хэмээн 4 зэрэгт хуваагдаж байв
Улсад туслагч гүн	Гүн цол- Манжийн үед ван, бэйл, бэйс, гүн гэсэн “Хэтэрхий дөрвөн хэргэм”-ийн нэг ба дотор нь түшээ гүн, улсад туслагч гүн, гүнгийн зэрэг засаг, тэргүүн зэрэг тайж гэж гурван зэрэг хуваадаг байжээ.
Бээжингийн Монгол журганы газраа...	Монгол Журган яам - Манж Чин улсын үеийн Монголын асуудлыг эрхэлсэн төв захиргааны байгууллага. Энэ яам нь Бээжин хотод төвлөн, Монголын аймаг хошуудын гол албан тушаалтныг томилох, ноёд, тайж нарын хэргэм зэргийг залгамжлуулах, Монголтой хамаа бүхий хууль цааз батлах, Монголд байсан хятад худалдаачдын асуудал зэрэг ажлыг хариуцдаг байжээ.
Жасаалан суух	Монголын том ноёд Монгол журганд ээлжээр очиж тогтмол алба хаахыг Монгол журганд жасаалах гэж хэлдэг байжээ. Жасаалах гэдэг нь ээлжийн алба гүйцэтгэх гэсэн утгатай.
Гангийн дархан	Гангийн дархан- Монгол дархны уламжлалд гангийн дархыг дархны урлагийн дээд гэж ярьдаг. Монголчууд ган төмрийн урлалаараа алдартай байжээ.
Далай Чойнхор вангийн хошуу	Одоогийн Архангай аймгийн Тариат сум, Хөвсгөл аймгийн Галт, Жаргалант сум, Шинэ Идэр сумын хагас
Чавганц дархан	Далай Чойнхор вангийн хошууны харьяат түүхэн хүн, алдарт дархны хоч нэр.
Түгээмэл Элбэгийн он	1850–1861 он

<p>Засаг ноёны зэрэг залгах</p>	<p>Засаг ноён - Манж Дайчин улс (1636-1911) болон Богд хаант Монгол улсын (1912-1923) үед монголын хошууны эрх барьсан тэргүүнийг хэлдэг байжээ. Тиймээс “зэрэг залгах” гэдэг нь засаг ноёны цол хэргэм, үүргийг дамжуулан авах гэсэн утгатай ажээ.</p>
---------------------------------	---

Алхам 3. Дараах даалгаврыг гүйцэтгэж, зохиолын талаар эргэцүүлбье.

<p>Даалгавар: Зохиолоос авсан дараах мэдээллээс уг зохиолыг түүхэн үндэстэй болохыг дүгнэж бичье.</p> <ul style="list-style-type: none"> • Сайн ноён хан аймгийн Жонон засгийн хошууны тэргүүн зэрэг тайж, улсад туслагч гүн Жамсранжавтан <ol style="list-style-type: none"> 1. Далай Чойнхор вангийн Чавганц дархан 2. Мэргэн Жа гүн.. Түгээмэл Элбэгтийн 8 дугаар оны орчин тэнгэрт хальж, түүний хөвгүүн ... засаг ноёны зэрэг залгажээ. <p>Дүгнэлт:.....</p>	
<p>Даалгавар: Хэтийг захиалж хийлгэсэн зорилгыг олж, өмнөх дугаарыг дугуйлъя.</p> <ol style="list-style-type: none"> 1. Жа гүн уран хийцтэй хэтээр гайхуулахыг хүссэн. 2. Монголчуудын уран дархны чадлыг манж нарт мэдүүлэхийг хүссэн. 3. Жа гүний хэт хуучирч муудсан 	
<p>Даалгавар: Зохиолын гол дүр Жа гүнийг “мэргэн” гүн болохыг батлах баримт 2-3 “ыг олж бичье.</p> <ol style="list-style-type: none"> 1. 2. 3. 	
<p>Даалгавар: Манж ноёд түшмэдийн ааль зан нэн ихэмсэг танхилзуур, хэр барагтай үг тоож дуугарахгүй ... байгаагийн шалтгааныг бичье. Шалтгаан:</p> <p>.....</p>	<p>Даалгавар: Манж ноён түшмэдийн ааш зан илт засарч, юлган зөөлөн болсны шалтгааныг бичье. Шалтгаан:</p> <p>.....</p>
<p>Монголын гангийн урлалын хөгжлийг харуулсан домгийн гол санааг илэрхийлсэн хэлцийг олоорой. А. Галуу дуурайж, хэрээ хөлөө хөлдөөх Б. Сайныг дагавал сарны гэрэл, Мууг дагавал могойн хорлол В. Биеийн хүчээр нэгийг дийлнэ. Ухааны хүчээр мянгыг дийлнэ. Г. Нэр хугарахаар яс хугар</p>	<p>Дараах оньсогод хэт цахиурыг хэрхэн оньсоголсныг тайлбарлаж, хэтийн бүрдэл хэсгийг мэдэж авъя.</p> <p>Байван хааны булигаарын өөдөс Балба дархны төмрийн өөдөс Гандаж хагдарсан өвсний өөдөс Газарт хэвтсэн чулууны өөдөс Тэр юу вэ? /хэт, цахиур, уул/</p>
<p>Далай Чойнхор вангийн Чавганц дархан Жа гүнтний захиалсан хэтний ганг хэдий хугацаанд хийв? Учрыг нь таамаглан, “Дархан хүн бурхан ухаантай” гэсэн санааг илтгэн эх зохиоё.</p>	

6

Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн он.....сар.....өдөр.....цаг.....
 Дууссан он.....сар.....өдөр.....цаг.....

СЭДЭВ: ТҮҮХЭН ДОМОГ

Дасгал 1. Зохиолын өгүүлэгдэхүүн бүтцийн холбоо хамаарлыг олъё.

АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР:

Эхлэл - Орчин, дүр, өгүүлэгдэхүүний талаарх суурь мэдээлэл.

Зангилаа - Зохиолын үйл явдал үргэлжлэх шалтгаан

Өрнөл - Зохиолын зангилаанаас учир шалтгааныг олохын тулд үргэлжлэх хэсэг

Туйл - Зохиолын хэрэг явдал, зөрчил тэмцэл туйлдаа хүрэх хэсэг

Тайлал - Зохиолын зөрчил шийдэгдэх хэсэг

Төгсгөл - Зохиолч тайллыг хэрхэн үзэж дүгнэснээ илэрхийлэх хэсэг.

Алхам 1: Дараах холбоосор орж хоёр хичээлийг үзье.

- “Зохиолын сэдэв, гол санаа, дүрээс төрсөн мэдрэмж сэтгэгдлээ бичих”


<https://econtent.edu.mn/lessons/EBS/7rangj/uran/1609>

- “Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, холбоо хамаарлыг тогтоох”

<https://econtent.edu.mn/lessons/EBS/7rangj/uran/1555>

Алхам 2: Дараах асуултын дагуу эргэцүүлж, зохиолын үйл явдлаар жишээлэн, дүгнэж бичье.

- Зохиолын зангилаа бол зохиолын үйл явдлын гол учир шалтгаан нь байдаг. Иймд 1.Зохиолын зангилаа яаж өрнөсөн бэ?, 2.Зангилаа яаж туйлдаа хүрэв? 3. Зангилаа яаж тайлагдсан бэ?, 4. Зангилаа төгсгөл хоёр хэрхэн холбогдож байна вэ?



7

Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн он.....сар.....өдөр.....цаг.....
Дууссан он.....сар.....өдөр.....цаг.....**СЭДЭВ:** ТҮҮХЭН. ТУУРЬ**АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР:****Өгүүллэг** - Роман, туужаас жижиг, хүний амьдралын нэгэн содон зүйл явдал, учрал, зурвасхан, агшныг хурц тод дүрслэн үзүүлдэг**Туурь** - Хэмжээ болоод дүрийн хувьд өгүүллэгтэй ойр боловч ихэнхдээ амаар дамжиж яригдаж ирсэн ер бишийн үйл явдал, гэнэтийн онцгой сонин учрал тохиолыг үзүүлсэн, хурц зөрчил, санаанд оромгүй уран шийдэлтэй байдаг.**Дасгал 1. Монгол туурийг уншиж, ойлгоё.****Алхам 1.** 7 дугаар ангийн сурах бичгийн 41- 44 дүгээр талаас “Шүхэрч Буनिया” зохиолыг анхааралтай уншъя.**Алхам 2:** Түүхэн зохиолыг сайн ойлгож уншвал зохиолд гарч буй цаг үеийн тухай мэдээлэл, хүмүүсийн үзэл бодол, соёл заншил, түүхэн үйл явдлын тухай олон зүйлийг мэдэж авч чадна.

Жишээлбэл, “Шүхэрч Буनिया” зохиолыг сайн ойлгохын тулд үгийн тайлбарыг харъя.

Үг	Тайлбар	Үг	Тайлбар
Автай сайн хаан	ХҮI зууны үеийн монголын түүхэн зүтгэлтэн	Арслан хэвтлэг	Лам нарын хэвтэх ёс бөгөөд нас барсан хүнийг тийн хэвтүүлдэг байжээ
Эрдэнэ зуу хийд	Автай сайн хан 1586 онд Эрдэнэ зуу хийдийг байгуулжээ.	Яс тавих газар	Тэр үед хүнийг ил хөдөө тавьж оршуулдаг байсан аж.
Зуугийн цам	Эрдэнэ зуу хийдийн цам Монгол даяар алдартай бөгөөд 108 дүртэй байжээ.Цам нь бурхдыг энэ ертөнцөд залж ирүүлэх утгатай зан үйл юм.	Хуучин муу журам	Гудас дэвсгэрийн хуучин нэр
Шарын шажин	Зонховын үүсгэсэн Буддын шашны салбар	Жуушаан утас	Ороомог утас
Шинэ хязгаар	Шинжаан , Тухайн үед Ойрадын нутаг байжээ.	Лойлин	Бурханы орны дүрслэл
Хувраг	Сахил авсан буддын лам	Номын баринтаг	Судар номын ороон боох бөс ороолт
Довжооны хайс	Сүмийн довжооны хашаа	Дуганч	Дуган сүмийг хариуцдаг лам
Их гэсгүй	Хийдийн журам, лам нарын сахилга батыг хариуцан сахиулагч ламын албан тушаал	Хүрд эргүүлэх	Дотроо тарни маань зэрэг шашны номын бичээс бүхий хүрдийг эргүүлэн бясалгал үйлдэх нэг арга
Торлогдох	Сахилга алдсан лам нарыг саваа модоор занчих	Буг шулам	Хүнд хор хөнөөл учруулах хүмүүн бус
Олон суваргат хэрэм	Эрдэнэ зуугийн хэрэм 108 суваргаар хүрээлэгдсэн байдаг	Бэрээгээрээ багана цохин цогдомдож	Гэсгүй лам бэрээ хэмээх саваагаараа багана цохих зан үйл
Винайн ёс	Номхотголын ёс буюу лам нарын сахиж явах ёс	Улиастайд суух зарлигийн манж сайд	Улиастай амбан сайд
Монгол улсын 18 он	1928 он	Тэнгэрийг тэтгэсэн хааны 10 он	1746 он



Алхам 3. Асуултад хариулж бичье.

1. “Тэнгэр тэтгэсний 10 дугаар оны бичиг хэргийн дансанд “Эрдэнэ зууд шүхэр хэрэглэж ниссэн банди Буनियाг торлогдон шийтгэсэн, торлог даалгүй үхсэн”-ийг мэдэгдсэн бичгийг үзсэн. Одоо амбасын хуучин данс хар үгүй тул түүхэнд орох гашуудалт тэр баримт үгүй боловч уран зохиолын нэг өгүүллэгт нэр нь орж хойчийн унших хүнд дурсагдаг гэж үүнийг бичлээ.” Эрдэмтэн гүүш Б.Ринчен гуайн энэ үгнээс үүдэн тухайн зохиол бичигдсэн

ач холбогдлыг юу гэж бодож байна вэ? Дүгнэж бичье.

.....

.....

2. “Шүхэрч Буनिया” туурийн дараах эшлэлийг анхааралтай уншаад, Буनियाгийн үйлдлүүдийг өнгөөр ялган зурж тэмдэглэе. Буनियाгийн үйлдлээс чи ямар эрхэм чанарыг өөртөө тусган хүлээж авч байна вэ?

Зуугийн гол сүмийн орой дээрээс дахин нисэх гэж шүхрээ үүрч гараад, татлага холбоог нь хоёр суган дороо бэхлээд доошоо үсрэн татлагыг нь ээлж ээлжээр татаж залсаар урьд урьд өглөөнийхөөсөө нэлээд хол буусандаа бахдаж шүхрээ яаран эвхэж , дахин сүм өөд сэмхэн хөл нүцгэн гүйхдээ, анх лойлинд орхимжоо дэлгэн нисэж явсан лам нарын бяцхан баримлыг үзсэнээсээ санаа авч, хулгайгаар ламын хэрэглэл, номын баринтгийн хуучин даавуу сэм зүүж, багшийнхаа хуучин шүхрийн үлгэрээр хийгээд хашаан дээрээсээ үүрийн шөнөөр үсэрч, шүхрийнхээ голд нь салхи дээшээ гаргах нүхтэй болгож, тэр хэмжээг нь их болгосоор давхар илүү байшингийн дээрээс зүрхлэн үсэрч сургуулийг хийж, шүхрээ хүн унтсан хойно хулгайгаар засаж, сэлбэсээр Зуугийн бага шиг дуган дээрээс үүрийн шөнөөр үсрэн хальж, эцэс сүүлдээ өндөр сүм дээрээс үсэрч, шүхрээ залж, улам улам ахиулан нисэж....

.....

.....

3. Хүсэл мөрөөдөлдөө тууштай үнэнч Буनिया хүү бидний цаг үед амьдарч байсан бол ... гэсэн санааг 3 өгүүлбэрээр бичье.

.....

.....

4. Дараах баримтаас чи юуг эргэцүүлж байна вэ? Товч бичье

Баримт 1: Эрдэнэ Зуугийн ядуу банди Буनिया шүхэр хэрэглэж нисэх оролдлогыг 1746 онд хийсэн.

Баримт 2. 1891 онд Отто Лилиенталь гэдэг герман хүн анх шүхэр хэрэглэж нисэхийг оролдсон



.....

.....

8

Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн он.....сар.....өдөр.....цаг.....
Дууссан он.....сар.....өдөр.....цаг.....


СЭДЭВ: ТҮҮХЭН ТУУРЬ

АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР:
Зохиолын баатруудын гадаад шинж, зан байдал, дотоод сэтгэлийн өвөрмөц онцлогийг илэрхийлсэн дүрслэлийг зохиолоос олж, үүндээ тулгуурлан задлан шинжилж болно. /Зохиолын дүрүүдийн гадаад болон дотоод шинж, зан чанар, үзэл бодол нь баатруудын хэл яриа, эдэлж хэрэглэж байгаа зүйл, амьдарч байгаа орчин зэргээр, үг яриа, үйл хөдлөл зэргээр нь дамжин илэрч байдаг./

Дасгал 1. Зохиолын дүрийг тодорхойлъё.

Алхам 1. 7 дугаар ангийн сурах бичгийн 56 дугаар талаас Ц.Түмэнбаярын “Цагаан сүүний домог” -зохиолыг уншъя.

Алхам 2: Зохиолын гол дүр Ойрадын Шар баатрын үйлдэл, үг ярианаас түүний зан төрхийг тодорхойлъё.

<p>1. Шар баатрын хийсэн үйлдэл</p> <ul style="list-style-type: none"> • Мориноосоо үсрэн бууж • Төвөнх нь гүрэлзэж хөл нь чичирч байлаа. • Хоолой чичрүүлэв • Сөхрөв. • Харуусал гуниг дүүрсэн духыг үнссэн. • Үлгэн салган амьтан арай ядан хөлөө зөөж гараад... 		<p>2. Шар баатрын үг яриа</p> <ul style="list-style-type: none"> • Нухацтай агаад догшин асуух • “...атаатны зулзага төрж” гэж шивэгнэв. • Тунхаглан зарла, хоолой зангируулан хэлээд... • Олзны хатнаас охин төрвөл өршөөнө. • Миний хатнаас голомт залгах хүү төрвөл халхтай байлдахыг зогсооно. • Чи юунд намайг мэхлэв,
<p>3 Дүрийн тухай дүрслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Өршөөл эрсэн хүлцэнгүй харц /хиагийн/ • Өлсгөлөн бүргэд олз харсан мэт догшин нүд • Хүрлэгэр царай • Хэзээ ч нулимс гарч байгаагүй гэмээр хурц догшин нүд 		
<p>4. Ойрадын Шар баатрын хийсэн үйлдэл, үг ярианаас түүний зан төрхийг тодорхойлъё.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>		

Алхам 3. Өмнөх задлалын дагуу зохиолын гол дүр болох Насан хатны зан төрхийг тодорхойлъё,

.....

.....

.....

9

Сурагчийн овог, нэр:
_____Эхэлсэн он.....сар.....өдөр.....цаг.....
Дууссан он.....сар.....өдөр.....цаг.....**СЭДЭВ:** ТҮҮХЭН ТУУРЬ**АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР:****Сэдэв:** Зохиолдоо бичихээр олж авсан зохиогчийн санаа бодлыг хэлнэ. Ихэвчлэн сэдэв гарчиг 2 тохирч байдаг. Зохиолд хэний тухай /юуны тухай/ гарч байна вэ?**Гол санаа /гол утга/:** Зохиолчийн зүгээс уншигчдад хандаж хэлье гэж онцлон өгүүлсэн санаа. Энэ зохиолоос юуг ойлгов? гэдгээр илэрнэ. Сэдэв нь гол утга санааны хураангуй, гол утга санаа нь сэдвийн дэлгэрэнгүй дүрслэл гэж ойлгож болно.**Дасгал 1.** Зохиолын сэдэв, гол санааг тодорхойлъё.**Алхам 1.** Зохиолыг уншаад, дараах үг хэллэгийн утгыг зөв харгалзуулж, мэдэж авъя.

1. Тулгар	А. Монгол гэрийн хаалга, хана хоёрын уулзвар газар
2. Хатавч	Б. Хүн болон хөхтөн амьтны умай дахь ургийг харвистай холбосон судсархаг эрхтэн
3. Хаяа	В. Жирэмсэн бие давхар Б. Шинэ тутам
4. Хүй	Г. Хоёр талдаа иртэй, шулуун, хуйд дүрж зүүх, сэлмээс арай бага, ган төмрөөр хийсэн хүйтэн зэвсэг
5. Илд	Д. Юмны зах, хөвөө, хязгаар: гэрийн хаяа (гэрийн хана, туурганы ёроол тал)

Алхам 2. Насан хатны “Хүүгийн амийг өршөө! Та минь өршөө! өршөө!” гэсэн үгийн далд утгыг зөв тайлсныг олъё.

- А. Олзны бүсгүй Монголжинг өрөвдсөн учраас
- Б. Хүүхдүүд хоорондоо солигдсоныг Шарбаатар мэдсэн учраас
- В. Ах дүү нарынхаа цусыг урсгасан аян дайныг дуусгахыг хүссэн учраас
- Г. Насан хатан охиноо Монголжинд өгсөн учраас

Алхам 3. Эхийн сэдвийг илэрхийлсэн хэсгийг олъё.

- А. Ойрад Монголын дайны тухай
- Б. Эхийн элбэрэл хайрын тухай
- В. Шарбаатар болон Насан хатан нарын хайр сэтгэлийн тухай
- Г. Насан хатан болон Монголжин нарын нөхөрлөлийн тухай

Алхам 4. “Тэртээ зүүн хаяанаас тэнгэр өндөрсөн үүрийн сүүн цагаан туяа орчлонг гийгүүлэн мандав аа.” гэсэн төгсгөлийн өгүүлбэрээр ямар санааг илэрхийлсэн бэ?

А. Эхийн хайр элбэрлээр халх ойрадын дайн дуусч, энх цаг ирж байгааг илэрхийлсэн.

- Б. Өглөө болж, нар мандаж буйг илэрхийлсэн.
- В. Зуны сайхан өдөр болох гэж буйг илэрхийлсэн.
- Г. Тэнгэрийн хаяанд боссон цагаан тоос харагдаж байгааг илэрхийлсэн.

Алхам 5: Дараах асуултад хариулъя.

1. Зохиолыг уншаад чамд ямар сэтгэгдэл төрсөн бэ?
2. Зохиолын ямар үйл явдал хамгийн гунигтай байсан бэ?
3. Зохиолын ямар үйл явдал хамгийн түгшүүртэй байсан бэ?
4. Чи зохиолыг уншаад ямар сургамж санаа олж авсан бэ?
5. Хэрвээ чи зохиолч байсан бол зохиолыг яаж төгсгөх байсан бэ? Яагаад?

10

Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн он.....сар.....өдөр.....цаг.....
Дууссан он.....сар.....өдөр.....цаг.....

СЭДЭВ: ТҮҮХЭН ТУУРЬ

Дасгал 1. Зохиолын өгүүлэгдэхүүний бүтцийг тодорхойлъё.

Алхам 1. Зохиолын үйл явдлыг зөв дараалалд оруулаарай. Хариултын хэсэгт дугаарыг бичье.

1. Шарбаатарын хатан Насан охин төрүүлж, олзны бүсгүй хүү төрүүлэв.
2. Халх Ойрадын дайн ширүүссэн цаг үе.
3. Ойрадын жанжин “Олзны хатнаас охин төрвөл өршөөнө. Хүү төрвөл дор нь ална. Миний хатнаас голомт залгах хүү төрвөл Халхтай байлдахыг зогсооно.” гэж зарлиг буулгасан.
4. Насан хатны сүүлчийн гуйлт
5. Насан хатан Монголжинд охиноо өгч, Монголжин хүүгээ зөрүүлэв.
6. Сүүн цагаан туяа орчлонг гийгүүлэн мандав.
7. Шарбаатар тунхаглан зарлав.

Хариулт бичих хэсэг: _____

Алхам 2. Туурийн үйл явдал өрнөх болсон шалтгаан буюу зангилаа нь юу байв?

- А. Насан, Монголжин нар хүү, охиноо сольсон явдал
- Б. Насан хатны сүүлчийн гуйлт
- В. Шарбаатарын буулгасан зарлиг
- Г. Шарбаатар хүүхдүүд солигдсон гэдгийг мэдсэн явдал

Алхам 3. “-Чи бид хоёр хаяа, хатавч хоёрт алтан ясаа хэлтэлж, алаг махаа тасалж эх боллоо! Май, Миний охиныг ав! Хүүгээ аль! Чамд үүнээс өөр хүүгийнхээ амийг аврах арга байхгүй. Охиныг минь өрнөөсөө унагасан үр шигээ өврөөсөө салгалгүй өсгөөрэй...” зохиолын энэ хэсэг өгүүлэгдэхүүний аль хэсэгт хамаарах вэ?

- А. Өрнөл
- Б. Зангилаа
- В. Туйл
- Г. Тайлал

Алхам 4. Дараах хүснэгтийг нөхөж гүйцээгээрэй.

Өгүүлэгдэхүүний бүтэц	Үйл явдал
Эхлэл	Халх Ойрадын хурц ширүүн тэмцэл, дайн болж буй байдал
Зангилаа	
Өрнөл	
Туйл	
Тайлал	Шарбаатар хүүхдүүд солигдсон гэдгийг мэдсэн ч Насан хатны сүүлчийн гуйлтыг биелүүлж, “Миний хатнаас хүү төрсөн” хэмээн тунхаглан зарлаж буй хэсэг
Төгсгөл	Тэртээ зүүн хаяанаас тэнгэр өндөрсөн үүрийн сүүн цагаан туяа орчлонг гийгүүлэн мандав аа.

Дасгал 5. Зохиолын эхлэл хэсэг, зохиолын төгсгөл хэсгээр зохиолч ямар санаа хэлэх гэсэн бол? Чи юу гэж бодож байна вэ?

Эхлэл: Амьтай бүхэн цэнгэн жаргамаар тунгалаг сайхан зуны өдөр.

Төгсгөл: Тэртээ зүүн хаяанаас тэнгэр өндөрсөн үүрийн сүүн цагаан туяа орчлонг гийгүүлэн мандав аа.

.....
.....

11

Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн он.....сар.....өдөр.....цаг.....
Дууссан он.....сар.....өдөр.....цаг.....

СЭДЭВ: ТҮҮХЭН ТУУРЬ

АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР:
Зохиолын гадаад ба дотоод орчин нь зохиолын сэдэв, утга, дүрийн зан төрхийг тодруулах гол нөхцөлийн нэг юм.
Цогц орчин – Түүхэн цаг үе, нөхцөл байдал, уур амьсгал, цаг хугацаа, зөрчил

Дасгал 1. Зохиолын орчин, нөхцөл байдал нь зохиолын сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж байгааг тайлбарлая

Алхам 1: Асуултад хариулъя.

Ц.Түмэнбаярын “Цагаан сүүний домог “ туурь “Амьтай бүхэн цэнгэн жаргамаар тунгалаг сайхан зуны өдөр. Тэртээ холоос уухайлан хашхирах дуу бүдэг бадаг сонсогдож, тэнгэрийн хаяанаас цагаан тоос манарна.” хэмээн эхэлж байна.

Асуулт:

- Энэ хэсгийн агуулгаас ямар таамаглал дэвшүүлж болох вэ? Яагаад уухайлан хашхиралдаж байна вэ? Яагаад тэнгэрийн хаяанд цагаан тоос манарч байгаа юм бол?

.....
.....

Асуулт:

- Тэгвэл зохиол “Тэртээ зүүн хаяанаас тэнгэр өндөрсөн үүрийн сүүн цагаан туяа орчлонг гийгүүлэн мандав аа” гэж төгсөж байгаа нь чухам ямар санааг далдуур илэрхийлж байгаа бол?

.....
.....

Асуулт:

- “Гэрийн баруун хатавчинд Ойрадын Шарбаатарын залуу хатан Насан, тэр тушаа гадаа хаяанд олзны бүсгүй хоёул ханын үдээр шажигнатал зуурч ёолон гиншинэ” гэсэн өгүүлбэрт хоёр бүсгүйн нэг нь хатавчинд, нөгөө нь хаяанд төрж байгаагаар үзүүлснээрээ ямар санаа илэрхийлэхийг зорьсон бэ?

.....
.....

Асуулт:

- Насан хатны “Ах дүү нарын хоорондох дайныг зогсоох юм сан” гэсэн хүсэл эрмэлзэлд ямар нөхцөл байдал гол нөлөө үзүүлсэн бэ?

.....
.....

Асуулт:

- Ойрадын Шарбаатар яагаад “Олзны хатнаас хүү төрвөл дор нь ална” гэж зарласан бэ? Таамаглал дэвшүүлье. Яагаад юу ч мэдэхгүй амгалан нойрсох нялх хүүг “ аман хүзүүгээр минь тас харвах атаатны зулзага ” гэж нэрлэсэн бэ?

.....
.....

Асуулт:

- Шарбаатар яагаад хүүг олзны хатнаас төрсөн гэдгийг мэдэж байсан ч “өөрийн хүү” гэж зарласан бэ?

.....
.....


12

Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн он.....сар.....өдөр.....цаг.....
Дууссан он.....сар.....өдөр.....цаг.....

СЭДЭВ: БИ УНШИГЧ

Чи хэр сайн уншигч вэ? Ярилцъя.



Асуултын дагуу эргэцүүлъя.

- Зургийн санааг товч тайлбарлан бичье.

.....
.....

- Чи хэр сайн уншигч вэ?

.....
.....

- Уран зохиолын номд дурлуулж, ном шимтэн унших шалтгаан болсон, хайрлаж явдаг номоо жагсаан бичье.

.....
.....

- Тэдгээр номоосоо хоёрыг сонгон, гол санааг нь тус бүрд хоёр өгүүлбэрээр илэрхийлэн бичье.

.....
.....

- “Миний номын санд хүний дээд бий” гэсэн үгийн утгыг чи юу гэж бодож байна вэ?

.....

- Танай анги номын сантай юу? Ангийнхантайгаа уншсан номоо хэр ярилцдаг вэ?


.....

- “Ном унших үед хүний тархи хамгийн идэвхтэй ажилладаг тул шинэ, их ач холбогдолтой, үнэ цэнэтэй бодол санаа дараа дараагаар төрж гардаг. Тэдгээрийг тэр дор нь тэмдэглэж авах нь чухал. Уншсан номын тэмдэглэл хөтөлдөг үү?

.....
.....

- Цахим номын сан, утга зохиолын блог, уншигчийн нүүр хуудсаар зочилдог уу? Тэндээс чи ямар шинэ, сонин, хэрэгтэй мэдээлэл уншдаг вэ?

.....
.....
.....
.....



shutterstock.com · 305753447

сэтгэлийг нь зөөлрүүлдэг.

Уран зохиолын ном уншихын ач тусыг чи юу гэж бодож байна вэ? Дараах мэдээллийг уншаад, сэтгэгдлээ бичье.

Энэ баахан тэнхээтэйдээ завдан нэгэн хуудас ном уншваас мөн илүү нэгэн өдөр амьдарсан мэт гавьяа болой.
В. Инжинаши

Ном нь хүнийг сэтгэлийг гэрэлтүүлж, өргөж, хүчирхэгжүүлж, түүний доторх хамгийн сайн хүсэл тэмүүллийг сэрээж, оюун ухааныг хурцалж, зүрх В.Теккерей

Хүүхдийн уран сэтгэмжийг хөгжүүлэх нь нэн чухал. Уран зохиол нь хүүхдийн уран сэтгэмжийг гайхалтай хөгжүүлнэ. Уран сэтгэмж нь хөгжсөн хүүхэд ер бусын баяр баясгалантай болно. Байгаа юмыг байгаагаар нь ойлгодог хүнтэй харилцахад хэцүү шүү дээ. Хүн төрөлхтний өдий болтол хөгжсөн нэг гол тулгуур нь уран сэтгэмж юм. Альберт Эйнштейн “Би хүүхэд байхдаа нарны цацрагийг дагаад гүйх юм сан гэж мөрөөддөг байсан” гэж дурссан байдаг. Энэ нь байх боломжгүй бөгөөд байгалийн хуулийг зөрчсөн зүйл юм. Харин ингэж мөрөөдөж чадаж байгаа нь уран сэтгэмж. Энэ уран сэтгэмжийнхээ үрээр л Альберт Эйнштейн агуу харьцангуйн онолоо нээсэн байж таарах нь. Уран сэтгэмж байгаагүй бол хүн төрөлхтний түүхэнд гарсан томоохон нээлт хийгдэхгүй байх нь. Уран зохиолын хичээлийн үнэ цэн үүнд л оршдог.

...Тэгэхээр ном уншсанаар ухаантай болчихдог гэдэгт би л хувьдаа итгэхгүй байна. Харин хоёр л зүйлийг баттай хэлж чадах нь нэгд, мэдээж хэрэг, мэдлэгийн хүрээ... үлэмжхэн тэлнэ, үүнээс илүү чухал зүйл нь хүний дотоод ертөнц ер бусын баялаг болно. Үүнийг бол би баттай хэлж, нотолж чадах юм. Нэг ном унших бүр дотоод ертөнцөд чинь нэг тийм мод цэцэглэн дэлгэрч буй хэрэг, дотоод ертөнцийн чинь тэнгэрт нэгэн шинэ од гялалзан гарч ирж буй хэрэг юм. Зохиол бүтээлээр нь дамжуулаад тухайн зохиолчийн дотоод ертөнцөд ургаж дэлбээлсэн тэр өөр өөрийн дахин давтагдашгүй өвөрмөц модод, цэцэгсийн үрсийг чи өөрийнхөө дотоод ертөнцөд авчран тарьж ургуулж буй хэрэг. Тэгэхээр хэр их ном уншина тэр хэмжээгээр дотоод ертөнцөд чинь ер бусын их баялаг, гайхамшигт цэцэрлэг шуугин, зүйл бүрийн шувууд шулганан, уул тал үргэлжилж, хот суурингуудад амьдрал буцалж, хүний хувь заяаны онцгой содон огтлолцлууд сүлэлдэн байх болно.

Б.Наминчимэд

Ном бидний өмнө огт өөр ертөнц нээж, амьдрал үнэртэж, тэмцэж, бүтээж, шаналж дурлаж, унаж, мөхөж, сэхэж буй түүх, хүн амьтан өөрсдийн араншин, юутай хээтэйгээ тодорно. Ном биднийг мөсөн уулын ёроолд аваачиж, тэндээс сэтгэхийг шаардаж, биднийг Египетийн пирамидын дэргэд аваачиж бодолд оруулдаг. Ном уншсаны дараа амьдрах хүсэл илүү оргилж, амьдралд шунан дурлаж эхэлдэг, хүнээр бахархах сэтгэл төрдөг.



.....

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр

СЭДЭВ: БИ УНШИГЧ

Сайн байна уу? Уран зохиолыг шимтэн уншигч чиний энэ өдрийн амар амгаланг эрье.



Номын талаар жаахан ярилцъя.

Хамгийн сүүлд шимтэн уншсан номын нэрээ бичнэ үү.

.....

Энэ ном яагаад чамд яагаад таалагдсан бэ?

.....

Сэтгэлд үлдсэн үг, өгүүлбэр, үйл явдлаас бичнэ үү,

.....

.....

.....

.....

7 дугаар ангийн уран зохиолын сурах бичигт орсон зохиолуудын нэрсийг уншаарай. Тухайн зохиолыг уншсан эсэхээ тэмдэглээрэй. (“Тийм”, “Үгүй” хариултаас сонгоё.)

7 дугаар ангид судлах зохиолоос миний уншсан зохиолууд:

- | | | |
|--|--------|--------|
| 1. Хангайн магтаал | 1.Тийм | 2.Үгүй |
| 2. Таван хошуу малын магтаал | 1.Тийм | 2.Үгүй |
| 3. Эмээлийн магтаал | 1.Тийм | 2.Үгүй |
| 4. Даахины ерөөл | 1.Тийм | 2.Үгүй |
| 5. Хорь Түмэд, Хоридай мэргэний түүхэн домог | 1.Тийм | 2.Үгүй |
| 6. Халхын дөрвөн хан цол авсан түүхэн домог | 1.Тийм | 2.Үгүй |
| 7. Мэргэн Жа гүний түүхэн домог | 1.Тийм | 2.Үгүй |
| 8. Арвай хээрийн түүхэн домог | 1.Тийм | 2.Үгүй |
| 9. Б.Ринчен “Шүхэрч Буनिया” | 1.Тийм | 2.Үгүй |
| 10. Л.Түдэв “Эрээн цоохор” | 1.Тийм | 2.Үгүй |
| 11. Ц. Түмэнбаяр “Цагаан сүүний домог” | 1.Тийм | 2.Үгүй |

Нийт хэдэн зохиол уншсан байна вэ? Баяр хүргэе.

Зохиолын тэмдэглэл бичих санаа:

- Номоо хүссэнээрээ ашигла. (Тодруулагчаар таалагдсан, чухал хэсгийг тэмдэглэ.)
- Эшлэл, ухаарал, шинэ санаа өгөх үг, өгүүлбэрийг тэмдэглэдэг тусгай дэвтэртэй болох
- Номоо уншиж дуусангуутаа тэмдэглэл хөтлөхийг эрмэлзэх
- Тэмдэглэлдээ жишээ, баримт оруулах
- Бусдад биш өөртөө зориулж бичих
- Бичих хүслээр дүүрэн байх



Номын тэмдэглэл бол зөвхөн чиний өмч

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Өгүүллэг гэдэг нь хүний амьдралын нэгэн содон зүйл явдал, учрал, тодорхой нэг тохиолдол, үйл явдлыг уран хэллэгээр товч тодорхой өгүүлэн бичсэн роман, туужаас хэмжээгээр богино хүүрнэл зохиолыг хэлнэ.

ДАСГАЛ 1: Зохиолын сэдэв, утгыг тодруулъя.



Алхам 1. Уран зохиол -7 сурах бичгийн 58-59 дүгээр тал Д.Нацагдорж “Хуучин хүү” өгүүллэгийг уншаарай.

Алхам 2. Их зохиолч Д.Нацагдоржийн талаар чи юу мэдэх вэ?

.....
.....

Их зохиолчийн ямар зохиолыг уншиж, сонссон бэ?

.....
.....

Алхам 3. Асуултад хариулж, их зохиолчийн “Хуучин хүү” зохиолын талаар эргэцүүлье.

1. “Хуучин хүү” ямар орчинд амьдарч байсан бэ?

Хөдөөгийн байдал шалдар булдар, цагийн улирал ороо босоо, элстэй шанд, буттай цайдмыг дагаж, хааяа нэг хар гэрээс утаа суунаглана. Дөрвөн зүг цэв цэлийн уйтгартай, цагаан униар тунана. Зуны лүгхийм халуун эсгий гэрийг шарж, малчин хүний сэтгэлийг бухимдуулна. Айлын хаяагаар үхрийн баас үргэлжилжээ. Үүгээр түүгээр хэдэн тугал оодогнон давхина.

2. “Хуучин хүү” ямар цаг үед амьдарч байсан бэ?

Өглөө бурханд залбирч, үдэш тэнгэр мөргөсөөр нэг насыг харанхуй манан дотор барна.

Тэртээ уулыг өнгөрвөл, айлгүй хэмээн бодож , тэнгэрийн хаяанаас цааш газаргүй гэж сэтгэсээр, түмэн хэргээс хоцорч дэлхий боловсролоос гээгдэнэ.

Гавж Жамбал хоймор сууж бурхан ном хэмээн буруу зөв чалчих ба зайсан Намжил гаднаас ирж, хууль ёс хэмээн худал ярихыг сонссоор, өдөр сарыг улируулна..

Хөлд орохоос аваад үс цайхыг хүртэл нэг голыг өгсөн уруудан нүүж, нэг худгийн эргэн тойрон нутагласаар, энэхүү ертөнцийг эцэслэнэ.

1. Эхний хэсэгт “Хуучин хүү” амьдарч байсан орчныг тоочин дүрсэлжээ.

2. Дараагийн хэсэгт “Хуучин хүү” ямар орчинд амьдарч, яаж өсөж хүмүүжсэнийг тоочин дүрсэлжээ.

Дүрслэл бүрийг маш анхааралтай, ойлгож унш.

Сонирхолтой үг, өгүүлбэрийн доогуур зур.

Тухайн үгсээр дамжиж чамд ямар мэдрэмж сэтгэгдэл төрж байна вэ? Товч бичье.

.....
.....
.....
.....
.....
.....
.....

Зохиолын дүрийг тодорхойлъя.

Алхам 4. Хүснэгтэд тохирох өгүүлбэрийг бичээд, “Хуучин хүү” –г тодорхойлъя.

Хуучин хүүгийн цог золбоог илэрхийлсэн өгүүлбэрийг бичье.

Хуучин хүүгийн гадаад төрхийг илэрхийлэх өгүүлбэрийг бичье.

“Хуучин хүү” гэж хэн бэ? тодорхойлъя.

... ухаан сэргэлэн хэмээвч, зүүн хошууны захад хүрсэнгүй, баруун мөрний тэртээ гарсангүй, зөвхөн гурав дөрвөн өртөө эргэн тойрон газрын оршин суусан тул, юуг үзэж мэдэж, юуг сонсох ажээ.

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Нас хэдийгээр залуу боловч үгээгүү ядуу өнчин балчир тул, нутаг сумын хэдэн айлд ээлжлэн зарагдсаар, олигтой аж амьдралын замыг нэгэнт алджээ.

Үг яриаг илээхийлсэн өгүүлбэрийг бичье.

Ажил үйлийг илэрхийлсэн өгүүлбэрийг бичье.

өвөлжөө зуслан, хаваржаа, намаржаа энэ дөрвөөс өөр явах газаргүй хэмээн санаж...

хөмөрсөн тогооны доторхтой адил хөдөөгийн бүдүүлэг байдалд хүмүүжинэ.

Алхам 5. Зохиолын санааг хөгжмөөр илэрхийлбэл түргэн, цоглог эсвэл гунигтай аялгууны алийг сонгох вэ? Яагаад вэ?

.....
.....

Алхам 6. Зохиолыг зургаар илэрхийлбэл ямар өнгө будаг голлох вэ? Яагаад вэ?

.....
.....

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Үгийн утгыг мэдье.

Сургаал үг- Ихэс дээдэс, ахмад настнаас бусдад зааж сургаж хэлэх үг. Монголчууд эрт цагаас эхлэн үр хүүхдээ сурган хүмүүжүүлэх, хүн шиг хүн болгохын тулд уран цэцэн яруу найраг,онч мэргэн сургаал үгсийг хэрэглэсээр иржээ

ДАСГАЛ 2.

Алхам 1: Сурах бичгийн 78-80 дугаар талаас “Оюун түлхүүр” сургаалын хэсгийг уншаарай.

Алхам 2. “Оюун түлхүүр” сургаалын зохиолын 4 мөрт болон “Харуул” эхийн санааг харьцуулан анхааралтай уншъя.

“Оюун түлхүүр”
сургаалаас

Өдөр явсан явдлыг шөнө шүүгтүн.
Ичгүүр гэмт явдлыг ятгаж орхигтун.
Олны дотор үгээ бэхэл.
Ганцаараа суухад сэтгэлээ шинжил.

Алхам 3: “Харуул” эх болон “Оюун түлхүүр” –ийн 4 мөртийг уншаад юу ойлгосноо нэг өгүүлбэрээр бичье.

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Харуул

Нэг өвгөн шөнө бүр голын хөвөөнд очин нам гүм суудаг байжээ. Голын эрэгт байх нэгэн баяны харшийн харуул нь шөнө бүхэн түүнийг гайхан аждаг байв. Нэгэн удаа сониуч зангаа барьж дийлэлгүй:

- Та үргэлж харуй бүрий болсон хойно голын хөвөөнд ирж суух юм. Ямар учиртай юм бэ гэж асуухад өвгөн:
- Та өөрөө юу хийдэг хүн бэ? гэж хариу асуув.
- Би “харуул” гэхэд
- Аан, би ч гэсэн харуул хийдэг юм гэжээ.
- Тийм бол яагаад харуул манаа хийх газраа орхиод энд ирдэг юм бэ? гэхэд:
- Бид хоёрт нэг ялгаа бий. Та бусдын гэрийг манадаг бол би өөрийн “дотоод гэр”- ийг манадаг. Хаа ч явсан тэр гэртэйгээ хамт. Түүнийгээ манаж харуулдах нь миний ажил гэж өвгөн хариулжээ.

Алхам 4. Асуултад хариулж, сургаалын зохиолын санааг эргэцүүлэе.

- Хүн үйлдлийнхээ манаач байж болох уу? Жишээ нь олны дотор үгээ бэхэлж болох уу?

.....
.....

- “Ганцаараа суухад сэтгэлээ шинжил” гэжээ. Сэтгэлээ яаж шинжих вэ? Чи өөрийн үг, үйлдлээ шинжиж үзсэн үү?

.....
.....
.....

- Оюун түлхүүр сургаалын зохиолоос (Сурах бичгийн 78-80 дугаар тал) өөртөө сургаал болгож хэлэх 4 мөртийг бичнэ үү, .

.....
.....
.....



Монгол шүлгийн шад, холбоцын талаар өмнө үзсэнээ эргэн саная.

Толгой холбох: Шүлгийн мөрүүдийн эхлэлийг ижил, ойролцоо дуудлагатай үе, үгээр холбож бичих.

Сүүл холбох: Шадын төгсгөлийг ижил болоод ойролцоо дуудлагатай бүтээврээр ижилсүүлэн төгсгөх

Шад: Шүлгийн нэг мөрийг хэлдэг бөгөөд нэг шадад орох үг, үеийн тоог тэнцүүлбэл шүлэг уран яруу, сонсголонтой болно.

ДАСГАЛ 3

Алхам 1. Өмнөх дасгал ажлын дэвтрийн 5 дугаар хуудсаас “Таван хошуу малын магтаал”- ыг толгой, сүүл холбоц болон шадын үг, үеийн тоог задалсныг эргэн хараарай.

Алхам 2. “Оюун түлхүүр” сургаалын хэсгийг уншаад толгой холболт, сүүл холболт, үг, үеийг хэрхэн тэнцүүлснийг ажиглаж доорх хүснэгтэд тэмдэглэе.

Үлгэрлэвэл:

- Өнөр хүн эвгүй болбоос Ө-нөр хүн эв-гүй бол-боос (7 үе, 4 үг)
- Өнчин хүний элэг болох Өн-чин хү-ний э-лэг бо-лох (8 үе, 4 үг)
- Олон хүн эвгүй болбоос О-лон хүн эв-гүй бол-боос (7 үе, 4 үг)
- Оорцог хүний идэш болох Оор-цог хү-ний и-дэш бо-лох (8 үе, 4 үг)

	Толгой холбосон арга	Сүүл холбосон арга	Шадын үг, үеийг тэгшитгэсэн байдал
1	ӨӨОО	болбоос, болох	4 үг, 7-8 үеэр шадыг тэгшитгэсэн.
2		нэн эрдэм	
3			6 үг, 13-14/11 үеэр тэгшитгэсэн.

Тойн хүний хамаг эрдмийн дотор нигүүлсэхүй сэтгэл нэн эрдэм
 Хаан хүний гучин таван эрдмийн дотор хайрлах сэтгэл нэн эрдэм
 Хатан хүний арван таван эрдмийн дотор сайхан ааль нэн эрдэм
 Түшмэл хүний есөн эрдмийн дотор төвшин сэтгэл нэн эрдэм

Арслангийн омог баатар мөн арсландаа зохих
 Үнэгний уран арга мөн үнэгэндээ зохих
 Арслан үнэг мэт явбаас түргэн гутах
 Үнэг арслан мэт явбаас түргэн үхэх .

Алхам 2.

“Оюун түлхүүр” сургаалын толгой, сүүл холболт буюу шүлгийн хэлбэрийг дуурайж, 4 мөрт сургаал зохиоё.

.....

.....

.....

.....

Зохиосон шүлгийнхээ сургамжит санааг хэлнэ үү.

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

ДАСГАЛ 4. Шүлгийг задлан шинжилье.

Алхам 1. <https://www.youtube.com/watch?v=19mtFcuolj8> шүлгээ сонсоорой.

Сурах бичгийн 87-88 дугаар талаас Д.Пүрэвдоржийн “Чингис” шүлгийг уншаарай.

Алхам 2. Асуултад хариулж, монголчуудын түүх, ахуй уг шүлэгт хэрхэн туссаныг тайлбарлаарай.

Амар заяа хомс доглон нулимст хорвоод
Аврах тавилан мөхөс долоон үеийн тэртээд
Атаа хорслын манцуйд Есүхэйн хүү өсч
Аян дайны онгодоор есөн тугаа тахисан юм.

4 мөртөд тэмдэглэсэн үгийн утгыг ахмад хүнээс асууж мэдэж аваарай. Яагаад эдгээр үгийг сонгосон болон монголын түүхтэй яаж холбогдох талаар товч бичье.

.....
.....
.....
.....

Чингис хааны голомт тулгыг нь тулж, тооноо өргөн барьсан гэр гэж юуг хэлж байна вэ?

Оонын халиун зоо шиг халхын саруул талд
Онгин цагаан тамга шиг гэрээ тэр барьсан юм
Эх орноо өмчилсөн гурван хасгийн хүрээлэнг
Элгэн ургаа өмөөрсөн дөрвөн тотгоор түшүүлж
Тулгар төрийн баганыг хорол тоонд өргөн
Туурга тусгаар Монголын голомтыг тэр тулсан юм.

4 мөртийн утгыг ойлгосноо бичье. Чингис хааны талаар чи юу мэдэх вэ? Гэрийнхэнтэйгээ ярилцаарай.

Чингисийн их Монгол ядарсан, гутарсан, задарсан
Чиний хөх Монгол ялсан, хөгжсөн, мандсан
Ямар ч байсан Чингис Хангарьд шиг хальж
Ял гавьяа хоёроо хойч үедээ даатгасан юм.

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

“Чингис” шүлгээс таалагдсан 4 мөртөө бичье. Яагаад таалагдсанаа тайлбарлаарай.

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Дууль - Эмгэнэлт баатарлаг аяст үйл явдал бүхий уянга туульсын зохиолын нэгэн төрөл- шүлэг

Дасгал 5. Зохиолын өгүүлэгдэхүүний бүтцийг тодорхойлъё.

Алхам 1. Зохиолыг анхааралтай уншаад, “Эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал” – гэсэн өгүүлэгдэхүүний бүтцээр зааглаж зураарай.

Айхавтар гар чангатай ах дүү хоёр байлаа
 Адалж хүмүүс тэднийг Харамчийнхан гэдэг байлаа
 Сансар эмгэдийн бэлийг хонь нь бүрхэн
 Сарваа цуцахын хөндийгөөр адуу нь багтаж ядаж
 Үе дамжсан баян харамчийнхны хот айл
 Үүл мэт навсийцгээн аж төрдөг байлаа.
 Гэм нь тэднээс бүтэн дээлтэй нь ховор
 Гэр нь бүрээс сайтай өвөлжлөө гэвэл худлаа
 Арван чимэгтэй эмээл, сайн морь эрчүүд нь эдлэхгүй
 Амаа мэдэхгүй үрээтэй бөг бөг шогшицгооно
 Хүүхнүүд нь дээлээ гурван наадмаар солихгүй
 Хүүхдүүд нь цас ортол гутлын бараа харахгүй
 Хониндоо барагтай бол хүрэхгүй, зээр гөрөөсхөн эргүүлж
 Холоос гийчин ирвэл хоормог тарагхан дөхүүлцгээнэ.
 Ганц хайрцаг шүдэнз хажуу айл нь гуйхад
 "Гал гаргадаггүй өдөр өө" гээд халгаахгүй буцаачихна.
 Хавийн улс амьтан хөх инээдээ барж
 Харамч муугийн үлгэр, үгийн хачир болгоно.
 Тэр л янзаар он жилүүд өнгөрсөөр
 Тэртээ жил гэнэтхэн дайн гарав.
 Халхын гол руу агт туух юм болж
 Хамгийн овоо гэснийгээ Бүрэнгийнхэн хөтөлж ирцгээв.
 Харамчийнхан л яадаг бол, гар тэнийхгүй дээ! гэж
 Хар амлацгаасан улс гайхаж гүйцэв.
 Суналзсан уургаа барьсаар мань Харамчийнхан
 Сумын төв дээр адуугаа багширтал хурааж ирлээ.
 Буруу зөвгүй номхон аль хурдан хурцыгаа
 Бузар дайсныг намнах баатрын хүлэг бол гэж өгцгөөлөө.
 Агт хөдлөөд хэдхэн хонотол
 Ах дүүсээс хоёр харамч цэрэгт мордсон юм.
 Хошуу нутагтаа алдартай харамч эцэг нь
 Хоёр хүүгээ амьтнаас түрүүн цэрэгт өгсөн юм.
 Цурамхийлгүй хүлээх ээж нь хоёр хүүгээ харамласангүй.
 Цурхиртал уйлах гэргий нь ханиа харамласангүй.
 Цуутай харамчийнхан юугаа ч харамласангүй ээ.
 Бүрээн дуунаар нөхдөө давших цагт
 Бүгдийн түрүүнд хоёр харамч явсан гэдэг юм.
 "Сумаа харамлаж байж энэ хоёр сүйд болно доо" гэж
 Суман, салааныхан нь дооглож үлдсэн гэдэг юм.
 Унахын учиргүй уул шиг хоёр сайхан хархүү
 Ургахын улаан нарнаар хоёулаа унасан гэдэг юм.
 Хамгийн хүнд мөчид Эх орон танаасаа
 Харамчийнхан амиа бас харамласангүй ээ.

Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц:

ЭХЛЭЛ: Зохиолын зөрчил тэмцэл гарах ахуй, нийгмийн нөхцөл, гол баатруудын тухай танилцуулах хэсэг


ЗАНГИЛАА: Зохиолын зөрчил үүсэж, үйл явдлын өрнөх шалтгаан болж буй хэсэг.

ӨРНӨЛ: Эгзэгтэй зангилааны учир зүйг олохын тулд чөлөөтэй өрнөж буй үйл явдлын бүрдэл хэсэг

ТУЙЛ: Зохиолын үйл явдал өрнөн хөгжиж, баатруудын зөрчил туйлдаа хүртэл хурцдаж, цаашид өрнөх боломжгүй болж, одоо яах бол гэж уншигчдын сэтгэлийг зовоож, анхаарлыг нь хамгийн их татдаг хэсэг

ТАЙЛАЛ: Зохиолын зөрчил шийдэгдэх хэсэг.

ТӨГСГӨЛ: Баатруудын хувь заяа хэрхсэн, зохиолч өөрөө яаж үзсэн зэргээ илэрхийлсэн хэсэг



Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр

ДАСГАЛ 5. Шүлгийг ойлгож, уран дүрслэлийг тайлбарлая.

Хүүхдүүд ээ, та нар тал нутгаар аялж байсан уу. Шүлгийг сайтар ойлгохын тулд тал нутгийн байгалийн зургийг интернетээс сонирхож болно шүү.

Алхам 1. Шүлгийг анхааралтай уншаарай.

Шөнийн талд адуу янцгаана. Д.Нямаа

Эртний домог шиг буурал тал
 Эргэн тойрон чимээ алдарна.
 Алс замын алжаал тайлж
 Аяны хүн талдаа хононо.
 Гүн харанхуйд тэнгэрийн заадас
 Гүүн зэл шиг сунайн цайрна.
 Амгалан талын аяс хөндөж
 Алдуурсан унага шиг од харвана.

Эртний домог шиг буурал тал
 Эргэн тойрон чимээ алдарна.
 Оддын дунд ижлээ үзсэн юм шиг
 Шөнийн талд адуу янцгаана.



Алхам 2. (https://www.youtube.com/watch?v=7AQ95_sPE1k) холбоосоор “Талын монгол айл” дууг сонсоорой.

Алхам 3. Шүлгийг уншихад чамд хамгийн түрүүнд юу төсөөлөгдөж байна вэ?

Алхам 4. “Эртний домог шиг буурал тал, Эргэн тойрон чимээ алдарна” гэсэн хэсэгт монголын тал нутгийг “Эртний домог шиг”, “Буурал” хэмээн адилтгасны учрыг юу гэж бодож байна вэ?

Алхам 5. Шүлгийн мөрүүд ямар уран дүрслэлээр бүтсэн бэ? Уран дүрслэлийг ойлгохын тулд зургийг ажиглаарай.

А. Гүн харанхуйд тэнгэрийн заадас Гүүн зэл шиг сунайн цайрна.

Б. Амгалан талын аяс хөндөж Алдуурсан унага шиг од харвана.

А. Б.



Алхам 5. Шүлгийг уншаад ямар мэдрэмж сэтгэгдэл төрж байна вэ? Зуны цэлмэг шөнө хээр хонож үзмээр санагдаж байна уу?

Зохиолын дүрийн зан төрхийг тодорхойлъё.

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 6. Зохиолын дүрийн зан төрхийг тодорхойлъё.

Д.Цэвэгмэдийн “Алагдай аварга” зохиолыг уншаарай.

Алхам 1. Зохиолыг уншаад, ажлын хуудсын дагуу задлал хийе.

Алагдайн гадаад шинжийг яаж дүрсэлсэн бэ?

Алагдайн үйл хөдлөл, яриаг яаж дүрсэлсэн бэ?

Жишээ нь:.....

.....
.....
.....
.....
.....
.....



Жишээ нь:.....

.....
.....
.....
.....
.....
.....



Алагдайн гадаад шинжийг дүгнэе.

Алагдайн гадаад дотоод шинжийг нэгтгэн зан чанарыг нь дүгнэе.

.....
.....
.....
.....
.....
.....



Алагдайн дотоод шинжийг дүгнэе.

Алхам 2. Зохиолын дүрийн үйлдлээс чи ямар сургамж авсан бэ?

.....
.....
.....

Алхам 3. Дараах санааг дэлгэрүүлэн бяцхан зохион бичлэг бичье.

“Ямаан омог эрдэм биш. Ярвагар зан чимэг биш”

.....
.....
.....
.....

Дорнын уран зохиол

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

ДАСГАЛ 8. Зохиолыг хам сэдвийн хүрээнд мэдэрч тусган хүлээж авъя.



Утга зохиолын хам сэдэв гэдэг нь дүрийг тодорхойлж буй тухайн цаг үеийн нийгэм-соёлын нөлөө, үйл явдал, үзэл бодол зэрэг зохиолын хамгийн их мэдээлэлтэй хэсэг юм. */Г.Нандинбилэг/*

Японы нэрт зохиолч Кавабата Ясүнаригийн “Ангийн даргын мөрдлөг” өгүүллэгийг “Уран зохиол VII” сурах бичгийн 118-123 дугаар хуудсаас уншин алхмуудыг гүйцэтгээрэй.

В. Тэдний тосгон тутарга тариалах болон хураах үеэр амсхийх ч завгүй болж, бага сургуулийн хүүхдүүд хүртэл туслахаар талбайд гардаг болохоор сургууль нь арав хоногийн тусгай амралт олгодог тариачдын тосгон байв.

А. Даваа гараг бол хамгийн сонирхолтой байгалийн ухааны хичээл ордог өдөр.



Алхам 1. Японы ард түмний уламжлалт аж ахуйтай холбоотой хэсгийг зөв тодорхойлоорой.



Б. Тутаргын навч шивээ өвсний толгой шиг аюултай билээ.

Г. Зэргэлдээ тосгонд тутаргын навчинд өрөөсөн нүдээ гэмтээсэн гэх нэг эмгэнээс өөр хүнгүй атал, ямар үйлийн үр юм бүү мэд.

Үгийн тайлбар: Тутарга – цагаан будаа

Алхам 2. Сэйчигийн нүд харахгүй болоход нөлөөлсөн хүчин зүйлсийг бичиж гүйцээнэ үү?

1. Тэдний тосгон тутарга тариалах болон хураах үеэр амсхийх ч завгүй болдог.
2. Бага сургуулийн хүүхдүүд хүртэл туслахаар талбайд гардаг.
3. Сэйчи аав ээжтэйгээ гурвуулаа л амьдардаг учраас багаасаа л тутаргын талбайд ажилласан.
4.

Алхам 3. Зохиолын төгсгөл хэсэгт Ошимото багшийн хэлсэн үгээс нөхөж гүйцээн бичиж, эндээс төрсөн бодлоо 1-2 өгүүлбэрээр бичээрэй.

“..... хараатай байна уу, үгүй юу огт асуудал биш...”

Чамд төрсөн бодол:

Дорнын уран зохиол

Дасгал 9. Зохиолын орчин, нөхцөл байдал нь зохиолын сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж байгааг тайлбарлая.

Японы нэрт зохиолч Кавабата Ясүнаригийн “Ангийн даргын мөрдлөг” өгүүллэгийг “Уран зохиол VIII” 2019 оны сурах бичгийн 118-123 дугаар хуудсаас уншин дараах алхмуудыг гүйцэтгээрэй.

Алхам 1. Зохиолын үйл явдал өрнөж буй орчин, нөхцөлийг тодруулж, сэдвийг тодорхойлохын тулд дараах асуултад хариулаарай. /Эхлэл хэсгийн асуултад жишээ болгон хариулав/

Асуулт	Эхлэл хэсэг	Гол хэсэг	Төгсгөл хэсэг	Зохиол бүхэлдээ
Үйл явдал?	Физикийн туршилт хичээл бүтэлгүйтсэн.			
Хэзээ?	Даваа гараг			
Хаана?	Сургууль дээр			
Ямар нөхцөл байдалд өрнөсөн бэ?	Туршилт хичээлийг хүлээн суусан сурагчдын урам хугарсан харц, багшийн ширүүн нухацтай байдал, зэрэг таагүй уур амьсгалтай орчин.			

Алхам 2. Зохиолын үйл явдлын орчин нөхцөлийг тодорхойлсноор бид энэхүү өгүүллэгийн сэдэв нь “Сурах хүсэл эрмэлзлийн тухай” гэж дүгнэж болох уу? Яагаад?

.....

.....

.....

Алхам 3. Зохиолын сэдэв “Сурах хүсэл эрмэлзлийн тухай” бол гол санааг юу гэж тайлбарлаж болох вэ?

.....

.....

.....

Дасгал 10. Зохиолын дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бичье

“Ангийн даргын мөрдлөг” өгүүллэг

Алхам 1. Сэйчиг илэрхийлэх үг хэллэгүүдийг түүн бичээрэй.

- Сэйчи нүд нь хардаггүй ч гэлээ юм бүхнийг мэддэг.
- Ээжээр өдөр бүр нэг хичээл уншуулж, дасгал хийсээр байгаад газар зүй, түүхийн сурах бичгийг цээжилчихсэн.
- Зөвхөн хичээл ч биш, ямар ч зүйл дээр хараатай хүмүүсийн дор орохгүй гэж шийдсэн.
- Ээж аавтайгаа гурвуулаа амьдардаг.
- Хар багын сайн тариачин байсан.
- Талбайн өвсийг зулгааж яваад хоёр нүднийхээ цэцгийг тутаргын навчинд эсгэчихсэн юм.
- Ээж ээ, би хараагүй болсон ч хараатай ямар ч хүнд ялагдахгүй шүү.

.....

.....

.....

.....

Алхам 2. Энэ бүхнээс дүгнэхэд Сэйчи бол:



.....

.....

.....

.....

.....

Алхам 3. Сэйчигийн дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бичээрэй.

.....

.....

.....

.....

.....


Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 11. Зохиолыг уншиж, соёл, түүхийн хам сэдвийн хүрээнд мэдэрч, тусган хүлээж авъя.

Америкийн нэрт зохиолч Эрнест Хэмингуэйн **“Өвгөн тэнгис хоёр”** хэмээх алдарт туужийг уншин даалгаврыг гүйцэтгэе. (Сурах бичгийн 125-134 дүгээр хуудсанд зохиолын хэсгээс нь бий.)

Алхам 1. Туужийг мэдэрч, ойлгож уншаад асуултад хариулаарай. Чиний бодлоор өвгөн ялсан уу? Загас ялсан уу? Яагаад?



Алхам 2. “Эхний дөчин өдөр өвгөнтэй нэг жаалхүү явжээ. Өдөр бүр гар хоосон ирээд байхаар нь хүүгийн эцэг эх “өвгөн лав сэло буюу огт ганзага нийлэхгүй хүн болсон байх” гээд ганзага нийлнэ хэмээн өөр загасчинтай явуулахад үнэхээр ч гурван сайн загас эхнийхээ долоо хоногт барьжээ.” гэсэн өгүүлбэрээс загасчдын амьдрал ахуй, уламжлал, хэв маягтай холбон дүгнэлт хийнэ үү?



Алхам 3. “Ганзага нийлэх” хэмээх хэлц үг нь монголчуудын хувьд аливаа ажил үйлсийг хамтарч бүтээхэд гар сэтгэл нийлэн, өөдрөг бүтэмжтэй байх гэсэн санааг илэрхийлдэг ба аян замд гарах, ажил үйл эхлүүлэхэд хамтрах хүнээ ивээл жилтэй бол сайн хэмээн үздэг нь бидний нүүдэлчин удмын ахуй соёл, уламжлалт шашин шүтлэгтэй холбоотой бол америкчуудын хувьд юутай холбоотой байж болох вэ? Таамаглан бичээрэй.



Өрнийн уран зохиол

Дасгал 12 Зохиолын орчин, нөхцөл байдал нь зохиолын сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж байгааг тайлбарлая

Америкийн нэрт зохиолч Эрнест Хэмингуэйн “Өвгөн тэнгис хоёр” хэмээх алдарт туужийг уншин даалгааврыг гүйцэтгээрэй. (Сурах бичгийн 125-134 дүгээр хуудсанд хэсгээс нь бий)

Алхам 1. Зургуудыг ажиглан зохиолын үйл явдал, орчин, нөхцөл байдлыг тохируулан бичээрэй.

Өвгөн алс эргээс холдон, илбээс загастай дэгээгээ хаяад, урсгал дагуу алгуурхан хөвөв. Нэгэн том загас өгөөшийг үмхэн, өвгөн дийлэхгүй загасанд чирэгдэн явсаар...



Далайд гарсан 85 дахь өдөр, нар улам хөөрсөөр, эргээс хол, эргэн тойрон хүний бараагүй их тэнгист аварга том загасанд чирэгдэн явах хүндхэн нөхцөл байдал






Түүний тэнгист гарснаас хойш гурав дахиа мандсан нар шингэх дөхөвч завь аяархан, тасралтгүй хөвсөөр ...



Эцсийн эцэст аварга махчин загаснуудад хамаг махыг нь зулгаалган алдсан ч гэсэн өөрийн барьсан том загасаа авчирч хоносон өвгөнтэй жаалхүү уулзсан.



Алхам 2. *“Хүн ялагдахын төлөө төрөөгүй юм.”* гэх өвгөний үзэл бодол, зохиолын үйл явдлын өрнөж буй гадаад орчин, нөхцөл мөн ганцаархнаа их далайд гурван өдөр, гурван шөнө аварга махчин загаснуудтай тэмцэхэд хүч болж байсан сэтгэлзүйн дотоод орчин нөхцөл зэргээс үндэслэн зохиолын утга санааг тайлбарлан бичнэ үү.



Өрнийн уран зохиол

Дасгал 13. Уншсан зохиолын сэдэв, утга санаа, дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бичье

Америкийн нэрт зохиолч Эрнест Хэмингуэйн “Өвгөн тэнгис хоёр” хэмээх алдарт туужийг уншин даалгаврыг гүйцэтгээрэй. (Сурах бичгийн 125-134 дүгээр хуудсанд хэсгээс нь бий)

Алхам 1. Сантьяго өвгөн жаалхүү хоёрын харилцан яриаг нөхөж бичээрэй.

-Сантьяго, би одоо тантай дахиад тэнгист гарч чадна. Бид жаахан мөнгө олсон шүү дээ.

-Үгүй, чи ганзага нийлэх завь олсон болохоор тэндээ бай.

-Таныг _____



Тийм ээ, тэгэхгүй яаж болох вэ.

- Аав ч таныг загас барина гэхэд төдий л итгэхгүй байдаг шүү.

Алхам 2. Тэдний харилцааны талаар өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бичнэ үү.

Алхам 3. Сантьяго өвгөний дүрийн дотоод шинжийг үргэлжлүүлэн бичээрэй.

Өвгөн биеэр ядруу, шилэн хүзүү нь гүн үрчлээс болсон, хацар нь халуун орны тэнгисийн гадаргуугаас ойсон нарны туяанаас үүсдэг өмөн үү хэмээх хоргүй өвчний хүрэн толбо болжээ... Өвгөний нүднээс бусад нь цөм өтөлснийг илтгэх агаад гагцхүү нүд нь тэнгисийн өнгөтэй адил. Хэр баргийн юманд бууж өгдөггүй сэргэлэн хүний нүд юм...



Зохиолын утга санааг эргэцүүлэе.

Америкийн нэрт зохиолч Эрнест Хэмингуэйн “Өвгөн тэнгис хоёр” хэмээх алдарт туужийг уншин даалгаврыг гүйцтгээрэй. (Сурах бичгийн 125-134 дүгээр хуудсанд хэсгээс нь бий)



Алхам 4 Зохиолын талаар эргэцүүлж, асуултад хариулья.

Зохиолд өгүүлсэн “Dentuso, Maco, Galanos” аварга загасны зургийг интернетээс хайж олж үзээд, өвгөн эдгээр аварга том махчин загасны эсрэг ганцаараа ямар аймшиггүй тэмцэлдсэнийг сэтгэлдээ төсөөлөн бодоорой. Өвгөний оронд чи байсан бол яах вэ?

.....
.....

Яагаад өвгөн хүнд хэцүү зүйл тохиолдоход жаалхүүг үгүйлж байна вэ? Жаалхүү чиний хувьд хэн бэ? Яагаад?

.....
.....

Өвгөн “Манолин, тэд намайг дийлсэн, тэд намайг ялсан” гэхэд жаалхүү “Тэр таныг өөрөө дийлж чадаагүй шүү. Загас таныг ялаагүй шүү дээ” гэж яагаад хэлсэн бэ? Энэ үгээрээ чиний бодлоор юуг илэрхийлэхийг хүссэн бэ?

.....
.....

Өвгөн Сантьяго 4 өдөр тэнгист гарсан боловч ямар ч загас барьсангүй. 85 дахь өдөр нь том загас барьжээ. Тэрээр тэнгист гарахдаа “Магадгүй өнөөдөр аз дайрч мэднэ. Өдөр бүхэн адилгүй шүү дээ. Хүнд аз дайрах нь сайхан байлгүй яахав. Гэвч би өөрийнхөө ажилд яв цав байх нь зүйтэй. Харин аз заяа ирсэн цагт бэлхэн хүлээж авна даа” гэж бодож байгаа нь өвгөний ямар чанарыг илэрхийлж байна вэ? Чамд ямар сургамж өгч байна вэ?

.....
.....

“Хүн ялагдахын төлөө төрөөгүй юм. Хүнийг устгаж болох боловч түүнийг ялж болохгүй юм” хэмээх өвгөний үгээс чи юуг ойлгож байна вэ? Товч бичнэ үү.

.....
.....
.....
.....

ДАСГАЛ АЖЛЫН ДЭВТРЭЭ АМЖИЛТТАЙ ДҮҮРГЭСЭН ЭРХЭМ УНШИГЧ ЧАМД БАЯР ХҮРГЭЕ



Энэ баахан тэнхээтэйдээ завдан нэгэн хуудас ном уншваас мөн илүү нэгэн өдөр амьдарсан мэт гавьяа болой. В. Инжинаши

Ном бол амьдралтай тэнцүү багш Зөв амьдрах, хүн шиг хүн болгох багш бол ном. Д.Урианхай



Дасгал ажлын дэвтрийн хүрээнд бид дараах зохиолыг уншиж, задлал хийж, эргэцүүлээ. Өөрт хамгийн их таалагдсан сэтгэлд нь хоногшсон зохиолын нэрийн дугаарыг дугуйлна уу. Хэдэн ч зохиол байж болно.

1. Д.Нацагдорж “Хуучин хүү”
2. “Оюун түлхүүр” сургаалын зохиол
3. Д.Пүрэвдорж “Чингис” шүлэг
4. Д.Цоодол “Харамчийнхны дууль
5. Д.Нямаа “Шөнийн талд адуу янцгаана”
6. Д.Цэвэгмэд “Алагдай аварга”
7. Кавабата Ясүнари “Ангийн даргын мөрдлөг”
8. Эрнест Хэмингуэйн “Өвгөн тэнгис хоёр”



shutterstock.com · 305753447

Эдгээр зохиолыг уншиж, эргэцүүлсний ач тус, үнэ цэнийг чи юу гэж дүгнэх вэ?

.....

.....

.....

.....

Уран зохиолын ном унших нь бидэнд ямар тустай вэ?

.....

.....

.....

Уран зохиолын ном уншиж, уран сэтгэмжээ хөгжүүлээрэй.

Чамд амжилт хүсье сайн уншигч минь.